

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

№ 17/4

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хуралдаж, хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав.

МБЗ-ийн хурлаар эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, эдийн засгийн өсөлт, эдийн засгийн гадаад орчин, хөдөлмөрийн зах, хөрөнгө санхүүгийн зах, зах зээлд оролцогчдын итгэл, эдгээрт гарч буй өөрчлөлтийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Жилийн инфляци 2016 оны 12 дугаар сараас эхлэн өсч 2017 оны 11 дүгээр сарын байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 7.6 хувьтай байна. Үүнд, 1) Махны үнэ өнгөрсөн оны сүүлийн хагаст огцом буурсан ч 2017 оны 8-11 дүгээр сард харьцангуй тогтвортой байснаар жилийн инфляцид үзүүлэх нөлөө эерэг түвшинд хүрсэн; 2) ХҮИ-ийн сагсны өөрчлөлт болон татварын нөлөөгөөр жилийн инфляци 4-5 дугаар саруудад нэмэгдсэн; 3) Ургац хураалтын урьдчилсан мэдээний дараа хүнсний ногоо болон гурилын үнэ өссөн; 4) Хатуу түлшний үнэ өмнөх онуудтай харьцуулахад эрт буюу 8-10 дугаар саруудад өссөн; 5) Өрхийн орлого сүүлийн 3 улирлын турш өмнөх оны мөн үеэс өссөн зэрэг нь инфляци нэмэгдэхэд нөлөөллөө.

Эдийн засаг хүлээлтээс давж өссөнийг уул уурхайн салбарын үйлдвэрлэл, бүтээн байгуулалт эрчимжиж, гадаад худалдааны нөхцөл сайжирч, богино хугацааны гадаад өрийн эргэн төлөлтийн дарамт буурч байгаагаас макро эдийн засгийн эрсдэл буурч, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэнтэй холбон тайлбарлалаа. Гэвч эдийн засгийн цаашдын төлөвөөс харахад бизнесийн зээл, уул уурхайгаас хамаарал багатай салбаруудын өсөлтийг дэмжих, ажилгүйдлийн түвшинг бууруулах шаардлагатай байгааг онцоллоо.

Төлбөрийн тэнцэл 2017 оны 3 дугаар улиралд ашигтай гарсан. Үүнд, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн (ӨСХ) хүрээнд Засгийн газарт АХБ-наас олгогдсон зээл, ГШХО-ийн өсөлт, экспортын гол бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлт хадгалагдаж байгаа болон гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэснээр худалдааны салбарын санхүүжилт нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлжээ.

Эдийн засгийн гадаад орчинд гарч буй өөрчлөлтийг худалдааны нөхцөл болон худалдааны түнш орнуудын өсөлтийн хүрээнд хэлэлцлээ. Манай эдийн засгийн гадаад эрэлтийг тодорхойлдог БНХАУ, ОХУ, Евро бүсийн эдийн засаг хүлээлтээс давж өссөн бөгөөд цаашид өмнөх төсөөллөөс бага зэрэг сайжирсан боловч цаашид буурах хандлага хэвээр байна. Харин худалдааны нөхцөл сайжрахад экспортын гол бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ өссөн нь нөлөөлсөн. Гэвч 2018 онд төмрийн хүдэр болон нүүрсний үнэ буурч, худалдааны нөхцөл өмнөх онтой харьцуулахад саарахаар байгаа ч өмнөх хүлээлтээс өндөр байх төлөвтэй байна.

МБЗ-ийн гишүүдэд Монгол улсын нэгдсэн төсвийн орлого, төсвийн алдагдлын ойрын төлөвийг танилцууллаа. Төсвийн алдагдлыг бууруулах, өрийн тогтвортой байдлыг хангах зорилттой нийцтэйгээр ирэх онуудад төсвийн бодлого чангарах хүлээлттэй байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд хэрэглээний зээл, засгийн газрын зээл, гадаад цэвэр актив өссөн нь голлон нөлөөлсөн. Хэдийгээр эдийн засаг өсч уул уурхай, худалдааны салбарын чанаргүй зээлд эерэг өөрчлөлт гарч байгаа ч бусад салбарт төдийлөн өөрчлөлт ажиглагдсангүй. Иймд банкууд зээлийн эрсдлээ бууруулах зорилгоор орлогоор баталгаажсан, эрсдэл багатай хэрэглээний зээлийг голчлон олгож, шинээр ажлын байр нэмэгдүүлдэг бизнесийн зориулалттай зээл өмнөх оноос өсөөгүй байна.

Ажил эрхлэлт нэмэгдсэн ч ажиллах хүчний оролцооны түвшин буурч, ажилгүйчүүдийн тоо буураагүй байна. Мөн өрхийн зардал өрхийн орлогоос хурдтай өсч байгаагаас өрхийн зээл өсч байна.

Төсөөлөл боловсруулахад учирч буй дараах тодорхой бус байдлыг онцлов. Тухайлбал, инфляцийн төсөөллийн хувьд нефтийн татвар болон хилийн үнэтэй холбоотойгоор дотоодын бензиний үнэ өсөх, өвөлжилтийн бэлтгэлээс шалтгаалан махны үнэ хэлбэлзэх болон төрийн зохицуулалттай бараа (сургалтын төлбөр, эрчим хүч, усан хангамжийн зардал, ...) -ны үнэ нэмэгдэх зэрэг тодорхой бус байдал байна. Мөн цаашид банкуудын активын чанарын үнэлгээ (AQR)-ний үр дүнгээс хамаарч банкуудад өөрийн хөрөнгийн дутагдал үүсэх, экспортын бараа, бүтээгдэхүүний үнэ хүлээлтээс өөрчлөгдөх, хил дээр экспортын тээврийн тарифын бус зохицуулалт удаан хугацаанд үргэлжлэх, байгаль, цаг агаарын нөхцлөөс шалтгаалан өвөлжилт хүндрэх, эдийн засгийн идэвхжил сайжирч гадаад валютын зээл нэмэгдэх, өрхийн өр чанаргүй зээлд шилжих зэрэг төсөөллийн тодорхой бус байдал байгааг онцлов.

Суурь төсөөллөөр 2017 онд инфляцийн түвшин зорилтот түвшнээс доогуур буюу 7.5 хувь, эдийн засгийн өсөлт 5.6 хувь орчимд байхаар байна. Хэдийгээр инфляцийн түвшин эрэлт болон нийлүүлэлтийн шалтгаантайгаар өссөн ч цаашид ажилгүйдлийн түвшин өндөр байх, бизнесийн зээл нэмэгдэхээргүй байгаа зэрэг нь инфляцийг бууруулах нөлөө үзүүлэхээр байна.

МБГ макро эдийн засгийн суурь төсөөллөөс гадна бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулах бодлогын альтернатив хувилбарыг танилцууллаа. Инфляцийн хүлээлтийн судалгаанаас үзэхэд инфляци зорилтот түвшнээс давахааргүйгээр хүлээгдэж байгаа бөгөөд бодлогын хүүг бууруулснаар инфляцийг зорилтот түвшинээс хэтрүүлэлгүйгээр эдийн засгийн идэвхжлийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.

Үүний дараа МБЗ-ийн гишүүн, Монголбанкны ССГ-ын захирал Д.Ган-Очир бусад Төв банкуудын мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл явцын талаар танилцууллаа. Зарим Төв банк мөнгөний бодлогын саналын шинжилгээ төсөөллийг боловсруулахдаа бусад шаардлагатай газар, нэгж болон МБЗ-ийн гишүүдийн саналыг тусгах уулзалтыг зохион байгуулдаг. Энэ хэлбэрт бодлогын шинжилгээ, төсөөллийн үйл ажиллагааг чиглүүлэх саналыг тавьсан. Мөн МБЗ-ийн хурлыг нээлттэй болон хаалттай хэлбэрээр хуралдуулж, гишүүдийн саналыг бодлогын саналд илүүтэйгээр тусгах боломжтойг онцоллоо.

Ийнхүү МБГ-ын зүгээс бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулах саналыг дэвшүүлэв. МБЗ-ийн хурлаар гишүүд МБГ-ын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөв.

Мөнгөний бодлогын саналын эсрэг байр суурьтай гишүүд цаашид инфляцид нийлүүлтийн шалтгаантай дарамт (мах, шатахууны үнэ зэрэг) нэмэгдэх эрсдэлтэй байгааг дурдсан. Мөн

макро зохистой бодлогын хэрэгслүүдтэй хослуулсан тохиолдолд бодлогын хүүг бууруулах арга хэмжээг авах нь илүү зохимжтой болохыг онцолсон.

МБГ-ын саналыг дэмжсэн байр суурьтай гишүүд бодлогын хүүг бууруулж, өсөлтгүй байгаа бизнесийн зээл, болон уул уурхайгаас хамаарал багатай салбаруудын өсөлтийг дэмжих, ажилгүйдлийн түвшинг бууруулах шаардлагатай гэсэн үндэслэлийг дэмжлээ. Мөн өмнөх оны мөн үетэй харьцуулахад валютын ханш тогтворжиж, гадаад богино хугацаат өрийн эргэн төлөлтийн дарамт буурсан нь бодлогын хүүг бууруулах орон зайг бий болгож байгааг дурдав.

Ийнхүү МБЗ-ийн зарим гишүүдээс бодлогын хүүг 1.5 нэгж хувиар бууруулах санал гаргаж, олонх нь нэг нэгж хувиар бууруулж 11.0 хувьд хүргэх саналыг дэмжлээ.

Дэлхийн санхүүгийн хямралын дараа улсуудын төв банкууд мөнгөний бодлого болон макро зохистой бодлогыг хамтад нь хэрэгжүүлж эхэлсэн. Монголбанк макро зохистой бодлого хэрэгжүүлэх, бодлогын хэрэгслүүдийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн судалж байгаагаа дурдсан. Ийнхүү арилжааны банкуудад хийгдэж буй активын чанарын иж бүрэн үнэлгээний үр дүнтэй уялдуулан 2018 онд макро зохистой бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаагаа хурлын төгсгөлд мэдэгдлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулж 11.0 хувьд хүргэх шийдвэр гаргасан. Мөнгөний бодлогын шийдвэрийг 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.